

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 он .01 дугаар сар .23-ны өдөр

Дугаар А/04/А/27

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоо бүрдүүлэх, нэвтрүүлэх, чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Ажлын хэсгүүдийн ажиллах удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Төслийн хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга С.Тунгалагтамир, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга Я.Буянжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/ нарт тус тус даалгасугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД
С.ЧИНЗОРИГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД
Д.САРАНГЭРЭЛ

2020-A-tushaal



Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоо бүрдүүлэх,
нэвтрүүлэх, чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын Зорилтот бүлэгт үзүүлэх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын мэргэжилтэн
Гишүүд:	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга Эрүүл мэндийн яамны Хүүхэд, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Эрүүл мэндийн статистик мэдээллийн удирдлагын зохицуулалт, явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Эрүүл мэндийн яамны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл Эрүүл мэндийн яамны Мэдрэл судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл

Эрүүл мэндийн яамны Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн дарга

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал

Хүүхдийн төв сувиллын Сэргээн засах, амбулаторийн тасгийн эрхлэгч

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн чанарын менежер

АШУҮИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхимийн төлөөлөл

АШУҮИС-ийн Өрхийн анагаах ухааны тэнхимийн төлөөлөл


Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбооны төлөөлөл

Монголын дауны холбооны төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Монголын аутизмын холбооны төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Монголын неврологийн нийгэмлэгийн төлөөлөл (зөвшилцсөнөөр)

АХБ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын Зорилтот бүлэгт үзүүлэх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлогын хэлтсийн дарга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын мэргэжилтэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын Тэгш хамруулан суралцуулах боловсролын бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр) Барилга, хот байгуулалтын яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн (зөвшилцсөнөөр) Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа, статистик, тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харъяа Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дарга

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Тэгш хамруулах нийгмийн сэргээн засалтын газрын дарга

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга

Улсын гуравдугаар төв эмнэлгийн Сэргээн засах эмчилгээний тасгийн тэргүүлэх зэргийн эмч

Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн төлөөлөл

Барилгын хөгжлийн төвийн төлөөлөл (зөвшилцсөнөөр)

МУБИС-ийн СӨБ-ын сургуулийн төлөөлөл

МУБИС-ийн тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн төлөөлөл

АШУУИС -ийн Сувилахуйн сургуулийн төлөөлөл

АШУУИС-ийн Сэргээн засах анагаах ухааны тэнхимийн төлөөлөл


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны тэргүүн (зөвшилцсөнөөр)

Түгээмэл хөгжлийн төвийн тэргүүн (зөвшилцсөнөөр)

Монголын аутизмын холбооны төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Монголын неврологийн нийгэмлэгийн төлөөлөл (зөвшилцсөнөөр)

АХБ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн



Ажлын хэсгүүдийн ажиллах удирдамж

1. Үндэслэл

Монгол Улсын Засгийн газар Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлээр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн (ХБИ) оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, оролцоог хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх зорилготой.

Төсөл нь (i) хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавхийг бэхжүүлж, тогтолцоог бүрдүүлэх, (ii) ХБИ-дэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, (iii) орчны хүртээмжийг сайжруулах, (iv) ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах, (v) ХБИ-ийг дэмжих стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тус төслийн үндсэн хэрэгжүүлэгч бөгөөд Эрүүл мэндийн яам I бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаа, үр дүнд бүхэлд нь, II бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаа, үр дүнд хэсэгчилсэн байдлаар дэмжлэг үзүүлэн ажиллана.

2. Зорилго

Ажлын хэсгүүдийн зорилго нь "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд "хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж хөгжлийн дэмжлэг эрт оролцооны тогтолцоог бүрдүүлэх, чадавхийг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн сэргээн засах, хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулах" бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцож буй зөвлөх үйлчилгээний компани, хувь зөвлөхүүдийн ажлын далгаврын гүйцэтгэл, явцын тайлан болон хүлээлгэн өгсөн эцсийн бүтээгдэхүүнийг хянаж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, тайланг хүлээж авах талаар санал дүгнэлт гаргаж, төслийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлнэ.

3. Чиг үүрэг

3.1. Бүрэлдэхүүн хэсэгт тусгагдсан арга хэмжээний хүрээнд сонгогдсон зөвлөх компанитай байгуулсан гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;

3.2. Зөвлөх компанийн гэрээнд туссан ажлын явцтай тухай бүр танилцан, гүйцэтгэлд хяналт тавих, ажлыг эрчимжүүлэх сайжруулах талаар зөвлөмж гарган Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, шаардлагатай бол төслийн Удирдах хороонд танилцуулах;

3.3. Эрхлэх хүрээний асуудлаар холбогдох байгууллагаас албан ёсны шийдвэр гаргуулахад дэмжлэг үзүүлэх;

3.4. Зөвлөх үйлчилгээ болон ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, холбогдох мэдээлэл, тоо баримтаар хангах, мэргэшсэн чиглэлийн дагуу мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;

3.5. Зөвлөхүүдийн гүйцэтгэсэн ажлын чанар, үр дүнг хэлэлцэж, тайлан, эцсийн бүтээгдэхүүнийг хүлээж авах эсэх талаар санал дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах;

3.6. Төслийн үйл ажиллагааны хүрээнд гарсан шинэ санаа, арга барил, туршлагыг нэгтгэн түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлж санаачилгатай ажиллах;

4. Үйл ажиллагааны чиглэл

4.1. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоо бүрдүүлэх хүрээнд

4.1.1. Зөвлөх компаниас боловсруулсан "Хүүхдийн хөгжлийн үе шатны үзүүлэлтүүдийн асуумж (ASQ)" болон "Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бэйли үнэлгээ-III (BSID-III)"-г ашиглах үйл ажиллагааны журмын төслийг хэлэлцэх, Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр (ягаан дэвтэр)-т өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэх, туршихад дэмжлэг үзүүлэх;

4.1.2. "Хүүхдийн хөгжлийн үе шатны үзүүлэлтүүдийн асуумж" болон "Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бэйли үнэлгээ-III"-г Монгол Улсад ашиглах эрх, бүтээгдэхүүний лицензийг авахад дэмжлэг үзүүлэх;

4.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох журам, зааврын хэрэгжилтийг үнэлж, гаргасан зөвлөмжид санал өгөх, чадавх бэхжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.4. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлтийн ХШҮ-ний тогтолцоог бий болгох, түүнчлэн мэдээлэл цуглуулах, боловсруулах аргагүйг бэхжүүлэх, одоо байгаа системтэй нэгтгэх, чадавхижуулах чиглэлээр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.5. "Хүүхдийн хөгжлийн үе шатны үзүүлэлтүүдийн асуумж" болон "Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бэйли үнэлгээ-III"-ын сургалтын модул, хөтөлбөр, сургалтын материалтай танилцан санал өгөх, сайжруулах чиглэлээр зөвлөмж өгөх;

4.1.6. Дээрх чиглэлээр зохион байгуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд хяналт тавих;

4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг бэхжүүлэх хүрээнд

4.2.1. Портеж эрт боловсролын хөтөлбөрийг судалж, нэвтрүүлэх, уг хөтөлбөрийг Монголд хэрэглэх зохиогчийн эрх болон лицензийг авахад дэмжлэг үзүүлэх;

4.2.2. Хөгжлийн төвүүдэд нэвтрүүлэх Портеж эрт боловсролын хөтөлбөр болон хөдөлгөөнт тоглоомын сангийн үйл ажиллагааны удирдамж, үйлчилгээ үзүүлэх ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, зардлын төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх;

4.2.3. Портеж эрт боловсролын хөтөлбөрийн талаар сургагч багш болон гэрээр үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг сургах хөтөлбөрийг боловсруулан батлуулах,

- сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- 4.2.4. ХНХЯ болон ХБХХЕГ-т хэрэглэгдэх Портеж хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний системийг боловсруулахад туслах, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 4.2.5. Сонгогдсон 6 аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвд байгуулах Хөдөлгөөнт тоглоомын сан дахь тоглоомын хэрэгцээг тодорхойлох, тоглоомын сангийн үйлчилгээний удирдамж, тоглоом зээлүүлэх үйлчилгээний журмын төслийг хэлэлцэн санал өгөх;
- 4.2.6. Хөгжлийн төвүүдийн үйлчилгээний загварыг боловсруулах, хууль тогтоомж, стандарт болон үйлчилгээний нөхцөл байдалд үнэлгээ хийж, бодлогын зөвлөмжийг эцэслэх;
- 4.2.7. Сонгогдсон 6 аймагт баригдах ХБИ-ийн хөгжлийн төвүүд болон Улаанбаатар хотод баригдах ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа мэдээллийн төвийн барилгын зураг төсөл боловсруулж, хяналт тавих Зөвлөх компанийг холбогдох мэдээллээр хангах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, барилгын зургийн ажил болон барилгын ажлын явцад хяналт тавих, зөвлөмж чиглэлээр хангах;
- 4.2.8. Хөгжлийн төвүүдэд шаардлагатай тавилга, туслах технологи, тоног төхөөрөмж, сургалтын хэрэгслийн жагсаалттай танилцан санал өгөх;
- 4.2.9. Хөгжлийн төвүүдийн үйлчилгээний дизайн, ажлын удирдамжид санал өгөх;
- 4.2.10. Хөдөлгөөн засалч, ахуй засалч, хэл засалч, орон зайн баримжаа олгох, нийгмийн ажил, ортопед техникч бэлтгэх сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж, уг хөтөлбөрүүдийг зохих боловсрол/эрүүл мэндийн байгууллагууд ашиглахад дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулахад дэмжлэг үзүүлэх;

5. Гарах үр дүн

1. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх ажил удирдлага зохион байгуулалтаар хангагдсан байна.
2. Эрт боловсролын хөтөлбөр (портеж)-ийг боловсруулж, хэрэгжүүлэх ажил эхэлж, мэргэжил арга зүйгээр хангагдсан байна.
3. Хөгжлийн төвүүдийн үйлчилгээний дизайн, хөдөлгөөн засал, ахуй засал, хэл засал, орон зайн баримжаа олгох, нийгмийн ажил, ортопед техникч бэлтгэх сургалтын хөтөлбөрүүд боловсрогдож, тэдгээр хөтөлбөрүүдийг зохих боловсрол/эрүүл мэндийн байгууллагууд ашиглах, мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх ажил хэрэгжиж эхэлсэн байна.

—оОо—